

Батлав: Засаг дарга  Б.Угтахбаяр

## ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

Дорноговь аймгийн мандах сум. Наадмын талбайн засвар тохижолтын ажил:

**А.** Ажил гүйцэтгэх хугацааны график хөдөлмөр зарцуулалт, үргэлжлэх хугацаа, ажиллах хүчний тоог тодорхой гаргаж ирүүлнэ. Мөн ажлыг гүйцэтгэх технологи аргачлал, техникийн тодорхойлолтыг боловсруулж ирүүлнэ.

**Б.** Барилгын норм ба дүрэм /БНБД/ стандартыг баримтлан технологийн дагуу чанартай гүйцэтгэх.

**В.** Үнийн саналд зураг төсвийн үнийг захиалагчийн хяналтын зардлыг, талбайн угсралтын ажлын төсөвт өртгийн дүнгийн 2%-аар, зохиогчийн хяналтын зардлыг захиалагчийн хяналтын зардлын 50%-аар тооцож тусгаж ирүүлнэ.

**Г.** Төсөв зохиохдоо Барилга, хот байгуулалтын сайдын 2012 оны 181 тоот тушаалын дагуу нэмэгдэл зардал, төлөвлөгөөт ашиг, техник хяналт, нормчлолын сан, НӨАТ, магадлашгүй ажлын зардал зэргийг тооцож Барилгын төсөв зохиох дүрэм БНБД "IY" 81-95-12/2020/-г мөрдлөг болгоно.

**Д.** Үнийн дүнгийн тарифын тоохон ирүүлэхдээ ажилбар тус бүрээр тооцож ирүүлнэ.

**Е.** Талбайн зохион байгуулалтын зураг, хөдөлмөр хамгаалал, аюулгүй байдал, аюулгүй ажиллагааг хангах төслийн баримт бичгийг тухайн ажилд нийцүүлэн боловсруулах.

### Өрөгт бүтцийн ажил

-Өрөгт бүтээцийн ажлыг зураг төсөвт заасны дагуу гүйцэтгэж БНБД 51-02-05-г баримтлана.

-Хиймэл зүлэг хийх талбайн суурийг 5 см бетон тэгшлэгээ хийж өгөх.

-Явган хүний зам суурийг элс хайрга-хайрганы хольцоор хийж сайтар нягтаршуулах.

-Барилга барих талбайг 90 морины хүчтэй бульдозероор тэгшлэх.

### Гадна, дотор цахилгааны ажил

-Гадна ханыг цемент шохойн зуурмагаар сайн чанартай шавардах

-Гадна ханад сайн чанарын замаск түрхэх

-Асрын гадна талын ханыг усан эмульсэн будгаар гар аргаар будах

-Асрын дээврийг уян битум шинглас дээвэр угсрах.

-Кабелын шуудууг 2-р зэргийн хөрсөнд гараар ухах, бетон суурь цутгах бетонд үлдэх ган бүтээцийг байрлуулах.

-Бетон суурьтай гадаа ил тоноглох гэрлийн самбар. Төсөвт заасан ажлыг чанартай хийж гүйцэтгэх. Аюулгүй ажиллагааг бүрэн хангах.

-Гадна гэрэлтүүлгийн ажлыг төсөвт заасны дагуу угсрах, 2.5 мм<sup>2</sup> хүртэл нийлмэл огтлолтой нэг ба олон судастай утас байх.

## Газардуулга ажил

50\*50\*50мм хэмжээтэй булан төмрөөр газардуулгыг гар ажиллагаатай зоох.

40\*40\*4 огтлолтой газардуулгын шинийг шуудуунд угсрах.

## Бусад ажил

Модон жорлон барих, зам талбайн ажил, бусад ажлыг төсөвт зааж өгсний дагуу чанартай хийж гүйцэтгэх шаардлагатай. Тендерийн баримт бичигт зураг төсөв, төсөв зэргийг оруулж өгсөн тул төсвийн дагуу чанартай хийж гүйцэтгэнэ. Төсөвт тусганаас өөр материал ашиглах, мэргэжлийн бус хүнээр гүйцэтгэхийг хориглоно.

### **Тендерт шалгарсан гүйцэтгэгч нь:**

1. Барилга байгууламжийн ажлыг батлагдсан зураг төсвийн дагуу, ажлын тоо хэмжээний дагуу чанарын өндөр түвшинд, гэрээний хугацаанд багтаан гүйцэтгэнэ. Хугацаа хоцорсон тохиолдолд алданги тооцно.
2. Гэрээнд тусгагдсан бүх ажлыг Монгод улсад мөрдөгдөж байгаа хууль тогтоомж, БНБД, стандартын дагуу хийж гүйцэтгэнэ.
3. Барилга байгууламжийн ажлыг эхлүүлэхдээ иргэдийн аюулгүй байдлыг хангуулах зорилгоор анхааруулга тэмдэг тэмдэглэгээг байршуулах, хашаа барих зэрэг шаардлагатай арга хэмжээг авч ажиллана.
4. Импортын материал сонгон худалдан авах тохиолдолд тохирлын гэрчилгээ, паспорт, лабораторын шинжилгээний дүнг хавсаргана. Үндэсний үйлдвэрлэлийн материал сонгосон тохиолдолд бүтээгдэхүүний тохирлын гэрчилгээг, лабораторын шинжилгээний дүнг, үнийн баримт зэргийг хавсаргана.
5. Барилгын талбайд ажлын журнал, батлагдсан зураг төсөв, хэрэглэгдэж буй материалын лабораторын сорилын дүн, тохирлын гэрчилгээ, гарал үүслийн бичиг баримтуудыг бэлэн байлгах.
6. Гүйцэтгэсэн ажил тус бүрт /ил далд ажил/ акт бичиж, схем зураг, фото зургаар баталгаажуулсан байна.
7. Барилга байгууламжийн ажлыг чанаргүй гүйцэтгэсэн тохиолдолд өөрийн хөрөнгөөр захиалагчийн заасан хугацаанд засварлаж өгнө.
8. Барилгын зураг төсөвд зааснаас зайлшгүй тохиолдолд өөрчлөлт хүсэлт оруулбал захиалагч болон зураг төсвийн байгууллагатай зөвшилцөнө. Зөвшөөрөлгүй газар дээр өөрчлөхийг хориглоно.
9. Хэрэв барилга байгууламж зураг төсөлд өөрчлөлт оруулах, материал хийц өөрчлөх тохиолдолд хүсэлтээ захиалагч байгууллагат бичгээр гаргаж хүсэлт гаргасан өдрөөс хойш 7 хоногийн дотор хариу өгнө. Зөвшөөрөөгүй тохиолдолд зураг төсвийн дагуу гүйцэтгэнэ.
10. Гүйцэтгэгч нь барилгын ажлын ил, далд ажлын актыг баталгаажуулж, үе шатны ажлын гүйцэтгэлийн тэмдэглэл хөтлөх, барилгын улсын хяналт хэрэгжүүлэх эрх бүхий байгууллага, зураг төсөл зохиогч, захиалагчаас тавьсан хууль ёсны шаардлагын бүрэн биелүүлнэ.
11. Энэхүү техникийн тодорхойлолтод заагдсан шаардлагыг биелүүлээгүй нөхцөлд захиалагчийн төлөөлөгч, мэргэжлийн хяналтын улсын байцаагч эрхийн дагуу барилгын ажлыг тодорхой хугацаагаар зогсоох хүртэл арга хэмжээ авах эрхтэй.
12. Монгол улсын "Барилгын тухай" хуулийн 14.3-т /Барилга байгууламжийг ашиглалтад зүгшрүүлэх тохируулах хугацаа нэг жил байна/ 14.4-т 14.3-т

заасан хугацаа дуусгавар болсон тохиолдолд гүйцэтгэгч зураг төсөв зохиогч захиалагч болон ашиглагч тухайн барилга байгууламжид хамтарсан үзлэг хийж зөрчлийг арилгах талаар тэмдэглэл үйлдэнэ. 14.5-д 14.4 заасны дагуу зөрчлийг арилгаснаар 14.3-т заасан хугацаа дуусгавар болсонд тооцно. 14.6-д /14.3-т заасан хугацаа дуусгавар болсноос хойш барилга байгууламжийн гадна дотор засал, бүх төрлийн материал, үндсэн хийц, бүтээц, цэвэр бохир ус, уур, хий дулаан, цахилгаан, харилцаа холбооны тоног төхөөрөмж, тоноглолын хэвийн ашиглалтын хугацаа 3-аас доошгүй жил байна./ гэж заасныг үндэслэн гүйцэтгэгч байгууллага чанарын баталгаа гаргаж өгнө.